

ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН АЛБА

Цахилгаан хангамжийн алба нь анх 1987 оны 10 дугаар сарын 29 – нд ашиглалтанд орж нийт 153,9 км цахилгаан дамжуулах Контактны сүлжээний агаарын шугам, 92,4 км кабель шугам, цахилгаан хувиарлан өөрчлөх 13 татах дэд станцын засвар үйлчилгээ ашиглалтыг хариуцан Цахилгаан хангамжийн албаны дарга, Цахилгаан хангамжийн ахлах инженер, контактны сүлжээний ашиглалтын мастер 1, контактны сүлжээний засварын мастер 1, татах дэд станцын засварын мастер 1, татах дэд станцын ашиглалтын мастер 1, кабелийн засварын инженер 1, цахилгааны ээлжийн диспетчер инженер 4, контактны сүлжээний засварчин 16, татах дэд станцын ашиглалтын цахилгаанчин 52 татах дэд станцын болон кабелийн засварын бригад 6, цахилгааны сэлбэгийн нярав 1, үйлчлэгч 2, лаборант 1 зэрэг 100 шахам хүний бүрэлдхүүнтэй байгуулагдан ажиллаж эхэлсэн.

Цахилгаан хангамжийн алба нь одоогоор троллейбусны 3 чиглэлд 50 км контактны сүлжээ, 61 км өндөр болон нам хүчдэлийн кабель шугам, 8 татах дэд станцын засвар үйлчилгээг хариуцан ЦХА-ны ахлах инженер 1, Контактны сүлжээний мастер 1, Татах дэд станцын инженер 1, Кабелийн инженер 1, контактны сүлжээний засварчин 12, татах дэд станцын ашиглалтын цахилгаанчин 32, Кабелийн засварчин 3, тусгай тоноглолтой автомашины жолооч 5, Цахилгаан хангамжийн ээлжийн инженер 4 нийт 60 хүний бүрэлдхүүнтэй ажиллаж байна.

Зорилго: Контактны сүлжээг найдвартай эрчим хүчээр ханган аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөн цахилгаан хангамжийн сааталгүй ажиллах үндсэн зорилго тавин ажиллаж байна. Цахилгаан хангамжийн алба нь шаардлагатай боловсон хүчнээ дотооддоо сурган бэлтгэх, ОХУ, БНХАУ – ын зах зээлээс өндөр үнэтэй худалдан авдаг сэлбэг материалыг дотооддоо үйлдвэрлэх, сэргээн засварлах зэрэг олон ажлыг хийж гүйцэтгэж байна.